

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр Дугаар БА-034/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул Дүүргийн 11 дүгээр хороонд баригдсан бага төвөгшилтэй ангиллын зорьтой 2 давхар, 56.1м*12.0м хүчин чадал бүхий аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/08/09 огноо, 0013328 дугаар, БАЗГ2023/521;

2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ХР-10/22;

2.3 Захиалагч: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (хуучнаар Байгаль орчин аялал жуулчлалын яам) оноосон нэр, 9085084 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Нэгдсэн үндэстний гудамж, Засгийн газрын 2-р байр холбоо барих утас, 51261966 цахим хаяг;

2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: "Молор Констракшн" ХХК оноосон нэр, 901117124 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2679213 регистрийн дугаар, БУ11-714/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, Дунд голын гудамж-1, "Монгол түлхүүр" ХХК-ийн оффис байр 325 тоот, 77101188, 85850088, 99993649 холбоо барих утас;

2.5 Барилга байгууламжийн Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй;

2.6 Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: "Хээрнүүд" ХХК оноосон нэр, 9011575142 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, ЗТ16-827/23 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо, Одкон холдинг 208 Б тоот, 99811557 холбоо барих утас;

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

2.7 Барилга байгууламжийн ашиглагч байгууллага: "Монголд суугаа Солонгос иргэдэд дэмжлэг үзүүлэх КАМ нийгэмлэг" ГҮТББ оноосон нэр, 9072007096 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 1028073 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6 дугаар хороо, Намянжү хотын соёлын төвийн байр 301-тоот холбоо барих утас, 450778 цахим хаяг;

2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан;

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Бага төвөгшилтэй ангиллын зорьтой 2 давхар, 56.1м*12.0м хүчин чадал бүхий аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ажлын 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛ
ГАЗАР

Барилга байгууламжийг аш
оруулах комисс


3.4 Комиссын акт хуудас, хуралдааны тэмдэглэл хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Бага төвөгшилтэй ангиллын зорьтой 2 давхар, 56.1м*12.0м хүчин чадал бүхий аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уулдүүргийн 11 дүгээр хороо, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
(хуучнаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам)-ны захиалгатай
Аялал жуулчлалын барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн дарга



(А.Мөнгөн)



Нарийн бичгийн дарга:
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн
яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн
бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн



(Г.Баяржаргал)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.




ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРОО, БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ (ХУУЧНААР БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМ)-НЫ ЗАХИАЛГАТАЙ ЗООРЬТОЙ 2 ДАВХАР, 56.1М*12.0М
“И ТЭ ЖҮН” ЭМЧИЙН ДУРСГАЛЫН ОРДНЫ БАРИЛГЫГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (хуучнаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам)-ны захиалгатай зоорьтой 2 давхар, 56.1м*12.0м, аялал жуулчлалын зориулалттай “И Тэ Жүн” эмчийн дурсгалын ордны барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 2 дугаар давхарт 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр 13:30 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 15:00 цагт дуусав.



Хуралд:

- | | | |
|----|---|---------------|
| 1 | Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | Б.Батчимэг |
| 2 | Комиссын нарийн бичгийн дарга: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн | Г.Баяржаргал |
| 3 | Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч | Ж.Жүгдэрмаа |
| 4 | Хяналт шалгалтын газрын Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 5 | Барилга хөгжлийн төвийн Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер | Г.Уртнасан |
| 6 | “Улаанбаатардулааны сүлжээ” ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн ХХХ-ийн дарга | Д.Сүхбат |
| 7 | “Эрчим сүлжээ” ХХК-ийн ашиглалтын инженер | Д.Билэгсайхан |
| 8 | “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн мэргэжилтэн | М.Жаргалан |
| 9 | Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер | Д.Болормаа |
| 10 | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, Хошууч | Б.Даваасүрэн |
| 11 | Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч | Э.Шижиртуяа |
| 12 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага | Н.Эрдэнэтөгс |
| 13 | Гүйцэтгэгч: “Молор Констракшн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал | Э.Ганболор |
| 14 | Зураг төслийн: “Хээрнүүд” ХХК-ийн захирал | Ц.Мөнхбаяр |
| 15 | Ашиглагч: “Монголд суугаа Солонгос иргэдэд дэмжлэг үзүүлэх КАМ нийгэмлэг” ГҮТББ менежер | Ц.Ербиш |

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (хуучнаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам)-ны захиалгатай зорьтой 2 давхар, 56.1м*12.0м, аялал жуулчлалын зориулалттай “И Тэ Жүн” эмчийн дурсгалын ордны барилгыг барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Ашиглалт хариуцах “Монголд суугаа Солонгос иргэдэд дэмжлэг үзүүлэх КАМ нийгэмлэг” ГҮТББ менежер **Ц.Ербиш:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч “Молор констракшн” ХХК-ийн захирал **Э.Ганболор:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч “Хээрнүүд” ХХК-ийн захирал **Ц.Мөнхбаяр:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Захиалагч Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн

Г.Баяржаргал:

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага **Н.Эрдэнэтөгс:**

- Гадна явган хүний зам, брожурт стандартын дагуу налуу хийх,
- 1давхарын ХБИ-н ариун цэврийн өрөөний суултуур угаалтуурыг стандартаар тоноглох
- Мөн 1,2-р давхарын эр ариун цэврийн өрөөнд шээлтүүрэнд 1,1-г тоноглох /баруул/
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Барилга хөгжлийн төвийн Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер **Г.Уртнасан:**

ХЯ

Барилга б

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан норм, нормативын сангийн төлбөрийг тооцуулан төлөх
- Гадна тохижилт зоорь 2-р давхарыг 1-3, А-D тэнхлэгийн дагуу өөрчлөлтийн зураг төсөл гаргаж, зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгах,
- 1,2-р давхарын дотор заслын хийгдээгүй ажилд ашиглагч байгууллагаас тайлбар албан бичиг ирүүлэх,
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивахлах архивч **Э.Шижиртуяа:**

- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх,
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэлийн тэмдэглэлд гүйцэтгэгч байгууллага баталгаа гаргах
- Архивд баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх
- Баримт бичгийн хуудсыг дугаарлах, дотоод томъёг үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай,

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, хошууч **Б.Даваасүрэн:**

- Гадна дулаалга дүгнэлт ил далд ажлын акт фото зураг үзүүлэх
- ГК-н хомут солих тэмдэглэгээ хийх ус тавьж шалгах
- Эрчим сүлжээ ХХК албан бичиг авах цахилгааны шитны өрөө өөрчлөлтөд
- Өөрчлөлтийн зураг үзүүлэх
- Галын дохиоллын систем батлагдсан зургийн дагуу хийх, шалгасан акт
- Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл MNS5566:2020 стандартын дагуу байрлуулах
- Авторын дүгнэлт авах
- Цахилгааны өрөөний хаалга металл болгож өөрчлөх
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай,

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер **Д.Болормаа:**

- Ундны усны шинжилгээ Нийслэлийн Эрүүл мэндийн газарт өгч дүгнэлт гаргуулах
- Ундны усны нөөцийн саванд ариутгал халдваргуужуулалт хийлгэн актаар баталгаажуулах
- Бохир усны худагт стандартын дагуу модон таг, шат суурилуулах,
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай,

“Эрчим сүлжээ” ХХК ашиглалтын инженер **Д.Билэгсайхан:**

- 0,4кВ самбарт схем бүдүүвч зураг байршуулах
- Өөрчлөлтийн зураг төсөлд хийцийг зурагт тэмдэглэх
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай,

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн дарга **Д.Сүхбат:**

- Халаах хэрэгсэлд тохируулах вентел тавих,

ИАЛТ ШАЛ
ГАЗАР

ийгууламжи
оруулах ко

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай,

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын ахлах улсын байцаагч **Ж.Жүгдэрмаа:**

- Барилгын ажлын тэмдэглэлд баталгаажуулалт хийж зохиогчоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт хянуулах мөн инженер даамлаас хүлээн авсан ажлын тэмдэглэл акт баталгаажуулсан байдлыг гүйцээж үзүүлэх,
- Зохиогчийн дүгнэлтийг дүрмийн дагуу бичиж, барилга бүтээц хэсгийн үүрэг даалгавар биелсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулсан талаар бичиж дахин хянуулах,
- Шатны арматурын хийцийн болон угсралтын фото зураг ил далд ажлын акт хянуулах,
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай,

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Огтолгооны худаг зургийн дагуу угсарсан эсэх /фото зургаар шалгуулах/
- Узелийн өрөөний тоноглолд бүрэн хаягжуулалт хийх
- Усны нөөцийн сав багасгасан дээр авторын дүгнэлтэд ашиглалтын хэвийн горимыг хангаж байгаа талаар тайлбар тусгах
- Дээвэр дээрх АС-ийн шаахтын угсралтыг фото зургаар шалгуулах
- Гадна дотор дулаан ус хангамж, агаар сэлгэлтийн ил далд ажлын акт шалгуулах
- АС-ийн механик системийн өөрчлөлтийн зураг, зоорийн давхар өөрчлөлтийн зураг шалгуулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай,

“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн мэргэжилтэн **М.Жаргалан:**

- Зоорийн давхарт кабелийн тавиур гүйцээж суурилуулах фото зургаар баталгаажуулах
- 1,2 давхарын үзэсгэлэнгийн хэсгийн танхимд хяналтын камер бүрэн суурилуулах фото зургаар баталгаажуулах гүйцэтгэлийн акт үйлдэх
- ХД-н гүйцэтгэлийн зураг хийх
- КаТВ оролтуудыг гүйцээж суурьлуулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай,

АЛТЫН

г ашиглалта
исс

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг:**

- БНБД 11-04-16 дагуу зохиогчийн дүгнэлтийг шинэчилж ирүүлэх,
- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 заалтын дагуу барилгын чанарын баталгааг гаргаж албан бичиг ирүүлэх,
- Зохиогч гүйцэтгэлийн зураг ирүүлэх,
- Комиссд захиалагчийн төлөөлөлийг комиссд төлөөлөн оролцуулах томилгоо тушаал ирүүлэх /БОАЖЯам/

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-Уул Дүүргийн 11 дүгээр хороо, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (хуучнаар Байгаль орчин аялал жуулчлалын яам)-ны захиалгатай зорьтой 2 давхар, 56.1м*12.0м, аялал жуулчлалын зориулалттай “И Тэ Жүн” эмчийн дурсгалын ордны барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:


Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч


9024041846
83145511 СБТ24866

(Б.Батчимэг)

Тэмдэглэл хөтөлсөн:

Комиссын нарийн бичгийн дарга:
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн


(Г.Баяржаргал)

д